



МАНГАЛЖАВЫН ЛУВСАНЧОЙНБОЛ

Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга
1962-1965 он

1916 онд нийслэл хүрээнд Мангалжавын гэр бүлд төржээ. Тэрбээр 1923-1933 онд бага, дунд сургууль, багшийн сургууль, 1944-1947 онд Намын боловсон хүчний дээд сургуульд суралцан төгссөн. 1938-1939 онд цэргийн алба хаах хугацаандаа эвлэлийн товчооны дарга, Бүх цэргийн намын комиссын нарийн бичгийн дарга, Дивизийн намын товчооны дарга, комиссараар ажиллаж байв.

1939-1940 онд Улсын худалдааны сургуульд багш, худалдааны байцаагч, 1940-1944 онд МАХН-ын Төв Комиссын байцаагч, Намын төв хорооны боловсон хүчний хэлтсийн эрхлэгчийн үүрэг гүйцэтгэгч, хэлтсийн эрхлэгч, 1947 оноос Улаанбаатар хотын намын хороонд зааварлагч, хэлтсийн эрхлэгч, нарийн бичгийн дарга, 1953 онд БНМАУ-ын Худалдааны

яамны сайд, дараа нь Хүнсний үйлдвэрийн яамны сайдаар томилогдон 1957 он хүртэл ажиллажээ.

1957-1960 онд Монгол нефтийн үйлдвэрийн удирдах газрын дарга, Аж үйлдвэрийн яамны сайд, 1960- 1962 онд Дорнод аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны даргаар ажиллаж байгаад.

1962-1965 онд Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга, 1965-1967 онд Дархан хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга, 1967-1970 онд Мэдээлэл радиогийн улсын хорооны харьяа зурагт радиогийн орлогч даргаар ажиллаж байгаад эрүүл мэндийн байдлын группэд ороод, 1974 онд нас баржээ.

М.Лувсанчоймбол Хотын захиргааны даргаар ажиллах хугацаандаа нийслэл хотыг хөгжүүлж тохижуулах, хүн амын бүх төрлийн үйлчилгээг өргөтгөх талаар хүчин зүтгэж, жинтэй хувь нэмэр оруулсан хүний нэг.

1962-1965 онд Нийслэлээ хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний дагуу хотод орон сууц, сургууль цэцэрлэг, ясли үйлчилгээний барилга барих ажил өрнөж, орон сууцны XII, XIV, XV хороолол, 220 мянгатын хоёрдугаар ээлжийн барилгын зураг төсвийн захиалга хийгдэж, зөвхөн 1964 он гэхэд 1000 гаруй айлын орон сууцны 27 байр, тус бүр 920 хүүхдийн арван жилийн сургууль гурав, 120 хүүхдийн цэцэрлэг гурав, 125 хүүхдийн ясли дөрөв, хүнс, хөдөө аж ахуйн барааны дэлгүүр, гуанз, ногооны зоорь, халуун ус зэрэг нийт 49 барилга объектыг ашиглалтад оруулсан байна. Хот тохижуулах ажил эрчимтэй өрнөж, 1964 оны эцэс гэхэд хотын нийт цэцэрлэгжүүлсэн талбай 634.0 мянган ам метрт тарьж ургуулсан мод, бут сөөг 408.3 мянган ширхэгт хүрч, нэг хүнд ногдох цэцэрлэгжүүлсэн талбай 8.8 ам метр болсон юм. Мод, бут сөөг ургуулах, цэцэрлэгжүүлэх аж ахуй байгуулж, хотын дотор услалтын алба буй болгосноос гадна гудамж талбайг гэрэлтүүлэх ажил амжилттай хийгджээ. Зарчимч шаардлага тавьж, байгууллага иргэдээс нийслэлийн өмнө хүлээх үүрэг хариуцлагыг өндөржүүлэхэд тэрбээр ихээхэн анхаарч байсан нь түүний ажлын арга барилын нэг онцлог болохыг тэр үед хамтран ажиллаж асан хүмүүс нь дурсан ярьсан байдаг. Түүний ажлын бүтээлийг үнэлж “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”, ойн медалиудаар шагнажээ.